

ОЛОН УЛСЫН “ГАН, ЦӨЛЖИЛТИЙН ӨДӨР”-ИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭВ

ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэн, БОАЖЯ хамтран “Гангийн үр дагаврыг хамтдаа давъя” уриан дор тэмдэглэн өнгөрүүлж байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 49 дүгээр чуулганы тогтоолоор, 1995 оноос эхлэн, жил бүрийн зургаадугаар сарын 17-нд “Дэлхийн Ган ба Цөлжилтийн Өдөр”-ийг тэмдэглэж байхаар болжээ. Манай улс НҮБ-ийн “Цөлжилттэй тэмцэх конвенц”-д 1996 онд элсэн орсон бөгөөд, Цөлжилттэй тэмцэх олон улсын өдрийг 2007 оноос тэмдэглэж ирсэн уламжлалтай.

06 дугаар сарын 16-ны өдөр

Ган, газрын доройтол, цөлжилтийн өнөөгийн төлөв байдал, ирээдүйн хандлага болон дасан зохицох, тэмцэх чиглэлийн сайн туршлагуудыг танилцуулж, цаашид Монгол Улсад ямар боломж, шийдэл байгаа талаар хэлэлцүүлгийг БОАЖЯ-ны Хаан танхимд 2022 оны 6 дугаар сарын 16-ны өдөр 13:30-13:45 цагт зохион байгуулав.



Уг уулзалт, хэлэлцүүлгийн нээлтийг БОАЖЯ-ны дэд сайд Л.Түвдэндорж эхлүүлж, эрдэмтэд цуврал илтгэлээр үйл ажиллагааг өрнүүлэв. үүнд:

- ✓ “Монгол орны гангийн нөхцөл байдал, цаашдын хандлага”сэдэвт илтгэл-УЦУОШХ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор П.Гомболүүдэв;
- ✓ “НҮБ-ийн Цөлжилттэй тэмцэх конвенцоос гангийн талаар гарсан шийдвэрүүд” сэдэвт илтгэл-БОАЖЯ-ны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Ариунтуяа;
- ✓ “Гангийн бодлого олон улсад хандлага, туршлага, сургамж” сэдэвт илтгэл- ШУА-ийн Газарзүй, Геоэкологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагын зөвлөх, доктор Н.Мандах;

- ✓ “Үндэсний тодорхойлсон хувь нэмэр ба ган, зудтай холбоотой зорилтууд” сэдэвт илтгэл-Уур амьсгалын өөрчлөлт, Парисын хэлэлцээрийн хэрэгжилтийн үндэсний зохицуулагч М.Сүхрагчаа;
- ✓ Монгол-Солонгосын хамтарсан "Ногоон хэрэм" төслийн үр дүн, иргэдийн оролцоо, ажлын байрыг нэмэгдүүлэх боломж" сэдэвт илтгэл-Монгол-Солонгосын хамтарсан "Ногоон хэрэм" төслийн зөвлөх Н.Баянхишиг;
- ✓ Газрын тогтвортой менежментийг дэмжих замаар газрын доройтлыг бууруулах боломж сэдэвт илтгэл-НҮБ-ын ХХААБ-ын Дорнод хээрийн төслийн менежер Т.Эрдэнэ жаргал;
- ✓ Санал зөвлөмжийг БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга А.Энхбат нар тус тус илтгэл тавьж санал, зөвлөмж солилцов.

Монгол улс 2026 онд НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх үндэсний өдөр 2026" 17 дугаар бага хурлыг зохион байгуулах үүрэг хүлээсэн бөгөөд, гангийн асуудлаар баримтлах бодлогыг тодорхойлж, гангийн мониторинг судалгааг чанаржуулах, үнэлэх, хохирлыг тооцох, эрсдэлээс сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай гэж дүгнэв.

06 дугаар сарын 17-ны өдөр

Монголын цөлжилтийн судалгааны анхны эрдэмтэн П.Цолмонгийн мэндэлсний 70 жилийн ойг тохиолдуулан “**Гандуу нутгийн газарзүй: Ган, газрын доройтол, цөлжилт**” сэдэвт залуу эрдэмтдийн эрдэм шинжилгээний бага хурлыг МУБИС-ийн лекцийн танхимд 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр 09:00-13:00 цагт зохион байгуулав.

Цөлжилт, газрын доройтлыг үнэлэх чиглэлээр 5, Газар ашиглалт, газрын нөөцийн менежментийн чиглэлээр 2, Ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн чиглэлээр 2 илтгэл тус тус хэлэлцүүлснээс МУИС-ийн Ойн генетик-экофизиологийн тэнхимийн оюутан Сарангуа "Говийн бүсэд тарималжуулсан модлог ургамлын өсөлт, биомассын хуримтлалд усалгааны нөлөө" сэдэвт илтгэл 1 дүгээр байр, Их нартын байгалийн нөөц газрын хамгаалалтын захиргааны мэргэжилтэн, докторант Д.Энхтүвшин "Цөлжүү хээрийн нам уулсын хөрсний физик шинж чанар болон сөөгөн бүлгэмдлийн өсөлтөд үзүүлэх зэрлэг туруутны бэлчээрлэлтийн нөлөө" сэдэвт илтгэл 2 дугаар байр, МУБИС-ийн Математик байгалийн ухааны сургуулийн газарзүйн тэнхимийн 4-р курсийн оюутан Б.Бадамгарав "Өвөрхангай аймгийн Хар хорин сумын тариалангийн газар ашиглалтад тулгарч буй асуудлууд, шийдвэрлэх арга зам" сэдэвт илтгэл 3 дугаар байр, ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн Цөлжилтийн судалгааны салбарын судлаач, магистр ЭШДЭА, Д.Отгонцэцэг "Ургамлан нөмрөгийн өөрчлөлтөөр цөлжилт газрын доройтлыг тодорхойлох нь" сэдэвт итгэл тусгай байрт тус тус шалгарлаа.



Мөн Цөлжилт, газрын доройтлоос үүдэж байгалийн тэнцвэрт байдал алдагдаж байгааг бодитоор харуулсан "Цөлжилт ба ой" нэртэй үйл ажиллагааг Монгол улсын нийслэл хотын төв Сүхбаатарын талбайд зохион байгуулав. Үүнд хоёр төрлийн тайз нөхцөл байдлыг харуулсан фото зургийн үзэсгэлэн, тусгайлан зассан ЛЕД дэлгэцэд “Монгол орны цөлжилтийн өнөөгийн байдал” болон “Аврал ойжуулалт” сэдэвт видео танилцуулгыг харьцуулан үзэх боломжийг бүрдүүлэв. Харьцуулсан үзэсгэлэн зэрэгцээ түвшинд байршин 50 метр үргэлжлэх ба ард иргэдийн дунд санал асуулга явуулах, сошиалд уриа гаргаж пост мэдээ хийх нөхцөлийг бүрдүүлж өгсөн болно.

Зохион байгуулагчид:



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ГАЗАРЗҮЙ, ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН
ИХ СУРГУУЛЬ

Дэмжигч байгууллага:



Implemented by

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH



Food and Agriculture
Organization of the
United Nations



ПЛАСТИК ДИЗАЙН

